

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31	
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК						
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	СУУДЛЫН ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ						
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал						
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр			Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай			2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм			<input type="checkbox"/> Үгүй			
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог			Нэр			
		Балсан			Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.								
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх							
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл								
9	Даатгалын зүйл	Даатгагдсан автомашины албан журмын гэрээнд нэр заагдсан жолоочийн амь нас, эрүүл						
	Даатгалын үндсэн эрсдэл	Даатгагдсан автомашин зам тээврийн осолд орсон улмаас даатгуулагч жолоочийн амь нас, эрүүл мэндэд учрах хохирол						
	Даатгалын нэмэлт эрсдэл	-						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0,7-1,5%						

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэл бүрдсэн;
2. Даатгалын гэрээнд заагдаагүй эрсдэлийн улмаас учирсан хохирол;
3. Даатгуулагчид хохирол учирсан талаар даатгагч болон эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэн шалгуулаагүй болон бусад шалтгаанаар хохирол учирсан шалтгаан тогтоогдоогүй, тодорхой бус байх;
4. Нөхөн төлбөрийн баримтуудыг даатгагчид хүлээлгэж өгөх энэхүү гэрээнд заасан хугацаа дуусгавар болсон;
5. Даатгуулагч согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үед учирсан хохирол;
6. Даатгуулагч гэмт хэрэг үйлдэх үед болон санаатайгаар өөрийн биед учруулсан хохирол;
7. Мэргэжлийн спортын уралдаан тэмцээн, усанд шумбах, бүхий л дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээр уралдаан тэмцээнд оролцсоны улмаас үүссэн осол гэмтэл;
8. Ан ав хийх үед учирсан хохирол;
9. Төрөлт, зулбалт, үр хөндөлт зэрэг жирэмслэлттэй холбоотой хохирол;

10. Даатгуулахаас өмнөх нөхцөл байдал, ердийн өвчин, архаг хууч өвчин, сэтгэл санааны сааталт, мэдрэлийн өвчин, цус харвах, унах татах өвчинтэй холбоотой хохирол;
11. Даатгуулагч нь даатгалд хамрагдахаас өмнөх ослын улмаас олсон гэмтлийн урхаг, хор нөлөөг эдгэрүүлэх, сэргийлэх үүднээс дахин эмчилгээ хийлгэн эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн бол;
12. Дайн, дайн бүхий байдал, зэвсэгт бослого, байлдааны зэвсэг хэрэглэх, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, бослого, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр, цацраг идэвхит бодис буюу туяаны хордлого, цөмийн дэлбэрэлт, улс төрийн тэмцэл зэрэгтэй холбоотой хохирол;
13. Салют, пуужин, хонгио, сум, дарь, нитроглицерин, шахаж савласан хийх, агаар, бутан, метан, бусад шингэн хий болон бусад тэсрэх, шатамтхай бодисний хэрэглээ, ашиглалт, тээвэрлэлттэй холбоотой учирсан хохирол;
14. Тухайн автомашиныг жолоодох эрхгүй буюу жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд нэр заагдаагүй жолоочид учирсан хохирол; эсхүл жолооны үнэмлэхний хугацаа дуусгавар болсон.
15. Тухайн автомашины жолоочийн суудлаас бусад суудалд учирсан аливаа хохирол хамаарахгүй;
16. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг цуцалсан эсхүл гэрээний хугацаа дуусгавар болсон үед учирсан аливаа хохирол;
17. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл